



МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛХЭЦ ӨГҮҮЛБЭРИЙН НЭГЭН ОНЦЛОГИЙН ТУХАЙД

Б.Мөнхтуяа, доктор

МУБИС-ийн Архангай аймаг дахь БС-ийн
Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн эрхлэгч

Резюме: В Монгольском языке предложения делятся по структуре: простые предложения, хэлхэц предложения, фразы. В хэлхэц предложениисказуемоголиниясположением, характером и структурой можно рассматривать как относительно обширного исследования. Моносубъектная полипредиктивная конструкция и разно-субъектная полипредиктивная конструкция в монгольском языке простые предложения-это с одним центром и соединение на основе приговор двух или более типов. Предложения с одним подлежащим и несколькими сказуемыми подвергнуты отдельными учёными лишь с точки зрения их строения, грамматических свойств и типов. Вот такая особенность в предложении, которая редко упоминается. Однако они в монгольском создают некую параллельную линию, в силу чего они представляют собой весьма особенный, комбинированный состав промежуточного уровня. Присутствие в одном предложении одного подлежащего и нескольких сказуемых автор, вслед за проф. П.Пурэв- Очир, склонен “хэлхэц”. Предложение с одним подлежащим и несколькими сказуемыми в монгольском языке, которое основано на параллельную любого другого члена, или любого члена предложения.

Түлхүүр үг: Үйлийн нэг эзэн, олон өгүүлэхүүн, зэрэгцлийн эгнээ, дундын ижил гишүүн

Монгол хэлний энгийн өгүүлбэрээс нийлмэл өгүүлбэрт шилжих зааг дээрх хам бүтэц бол үйлийн нэг эзэнтэй олон

өгүүлэхүүнтэй өгүүлбэр юм. Эрдэмтэд энгийн ба нийлмэл өгүүлбэрийн завсрын түвшний нэгж болох үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэрийг өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний цуваа байрлал, шинж чанар, бусад өгүүлбэртэй ижил төстэй ба ялгаатайн талаар судалж ирсэн хэдий ч энэ хэв шинжийн өгүүлбэрт байх логик бүтэц, тогтолцоот шинжийн талаар харьцангуй бага өгүүлсэн байдаг.

Орчин цагийн хэл шинжлэлд тухайн хэлний өгүүлбэрийн бүтэц, хэв шинжийг шууд бүрдүүлэгчийн аргын зэрэгцээ хувиргалын аргаар судлах нь ихээхэн үр дүнтэй гэж үзэж байгаа бөгөөд монгол хэлний үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр (хэлхэц)-ийг энэ аргаар дэлгэрүүлж судлах нь хэлний үндсэн ба завсрын түвшний нэгжийн ялгааг тодруулах, бүтэц тогтолцоог нь нээн гаргахад чухал ач холбогдолтой.

Монгол утга зохиолын хэлний төрөл бүрийн найруулга дахь өгүүлбэрийн бүтэц, хэвшинжийг ажиглан, ангилан бүлэглэж байхад нэг талаар энгийн өгүүлбэрт, эсвэл нийлмэл өгүүлбэрт оруулмаар, бас зарим нь зэрэгцсэн нийлмэл өгүүлбэртэй, нэг хэсэг нь угсарсан нийлмэл өгүүлбэртэй төстэй хэсэг бүлэг өгүүлбэр байдаг ба тэдгээрт зэрэгцлийн эгнээ, дундын ижил гишүүн зэрэгтэй холбогдох онцлог шинжүүд ч харагддаг. Монгол уран сайхны эхийн найруулгаас энэ хэв шинжид хамруулан бүлэглэсэн 300 гаруй өгүүлбэрийг судалгааны эх сурвалж болгон задлал хийж үзэхэд, нэг талаас, хэлхэц өгүүлбэрийг бүрдүүлж буй хэлхэц гишүүд нь дундын нэг ижил гишүүнтэй байх, нөгөө талаас, хэлхэц гишүүд нь

зэрэгцсэн ба угсарсан байдлаар эгнээ үүсгэх зэрэг онцлогтой байгаа юм. Монгол хэлний өгүүлбэрийг бүтцийн ерөнхий хэв шинжээр нь буюу ерөнхий байгуулалтаар нь энгийн, нийлмэл гэж хоёр анги болгон авч үздэг.”(Орчин цагийн монгол хэлний зүй, 1966) уламжлалт ангиллаас гадна “энгийн өгүүлбэр, хэлхэц өгүүлбэр, хэллэг өгүүлбэр, гэ-, хэмээ- жинхэнэ нийлмэл өгүүлбэр” (Базаррагчаа, 2005) гэх буюу энгийн өгүүлбэр, энгийн ба нийлмэл өгүүлбэрийн завсрын түвшний нэгж, нийлмэл өгүүлбэр (Пүрэв-Очир, 2001) хэмээн ангилсан байна. Эдгээрээс “хэлхэц өгүүлбэр” буюу “энгийн ба нийлмэл өгүүлбэрийн завсрын түвшний нэгж”-ийн тухай асуудал нь зарим талаараа маргаантай, бас зарим талаараа харьцангуй бага судлагджээ. Энэ хэв шинжийн өгүүлбэрийн судлагдсан байдлыг авч үзвэл,

Нэгд, Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц хэв шинж, ангиллын талаас үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэрийг хэрхэн авч үзэх тухайд, академич Ш.Лувсанвандан, “Энгийн өгүүлбэрт нэгээс илүү өгүүлэхүүн байдаггүйг үндэс болговол зэрэгцсэн өгүүлэхүүнтэй, үйлийн нэг эзэнтэй өгүүлбэрийг энгийн өгүүлбэрт багтаах нь эргэлзээтэй юм.”(Хэл зохиол, ХХI боть, 1977) хэмээн үзсэн бол, эрдэмтэн М.Базаррагчаа, “А. Багш хэлэв. (энгийн өгүүлбэр), Б. Морь унасан хүн ирлээ. (хэлхэц), В. Батыг очиход багш Баяр хүргэжээ. (хуурмаг нийлмэл өгүүлбэр буюу хэллэг), Г.Бат очно гэж багш хэлэв. (жинхэнэ нийлмэл өгүүлбэр) гэж ангилж болмоор санагдана гээд, “б” өгүүлбэр нь “а, в” өгүүлбэрийн дундын шижтэй, “в” өгүүлбэр нь “б, г” өгүүлбэрийн дундын шинжтэй болно. “а, г” өгүүлбэр нь энгийн ба нийлмэл өгүүлбэрийн тус тусын шинжийг дор дороо агуулсан, гоц ялгарах бүтэцтэй бол “б, в” өгүүлбэр нь “а, г” хоёрын завсрын шинжтэй бүтэц бүхий өгүүлбэрүүд юм.”(СХСэтгүүл, 1986) гэжээ. Тэгвэл, эрдэмтэн Б.Пүрэв-Очир, “Монгол хэлний энгийн өгүүлбэрээс нийлмэл өгүүлбэрт шилжих зааг дээрх хам бүтэц бол үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй хам бүтэц (моносубъектная полипредикативная конструкция), үйлийн олон субъекттэй, олон

өгүүлэхүүнтэй хам бүтэц (разно-субъектная полипредикативная конструкция) юм. (2010,х.270) гэж тайлбарлажээ.

Монгол хэлний энгийн өгүүлбэр нь нэг төвтэй, нийлмэл өгүүлбэр нь хоёр буюу хэд хэдэн төвтэй хэвшинжүүд байдаг (Барайшир, 1989, х.203). Эдгээрээс арай нэг өөр хэв шинж, энгийн ба нийлмэл өгүүлбэрийн завсрын түвшний хэв шинж байгаа талаар эрдэмтэд тайлбарлан, хэллэг, хэлхэц, холбоо үг, гишүүн өгүүлбэр, хавсарсан өгүүлбэр, дэлгэрэнгүй гишүүн гэх мэтээр нэрлэж ирсэн байна.

Хоёрт, Үйлийн нэг эзэнтэй, олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр нь бүтэц, хэв шинж, тогтолцооны хувьд “өвөрмөц” хам бүтэц болох талаар, “Олон өгүүлэгдэхүүн буюу үйлийн олон эзэнтэй, нэг өгүүлэхүүнтэй хам бүтэц орно. Үйлийн нэг эзэнтэй, олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр байна. Энэ нь бүтцийн ерөнхий шинжээрээ дээрхтэй эсрэгцсэн хам бүтэц болно” (Пүрэв-Очир, 1997). “Нэг өгүүлэгдэхүүн нь хэд хэдэн өгүүлэхүүнтэй байж болно. Зэрэгцсэн өгүүлэхүүнээс бусад гишүүд зэрэгцэж орвол хэлхэц болно. (Базаррагчаа, ба бус, 1999) хэмээн тодорхойлсноос үзэхэд энэхүү завсрын түвшний нэгж нь бүтэц тогтолцооны хувьд нэг эзний олон үйлтэй, олон эзний нэг үйлтэй, эсвэл бусад гишүүнийн зэрэгцэлтэй хамааралтай байдаг тухайд авч үзсэн байна.

Гуравт, Монгол хэлнүүдийн олон өгүүлэхүүнтэй хам бүтцийн холбох хэрэглүүрийн задлаг нийлэг шинж, өгүүлэхүүний хэлзүйн хэлбэрийн учир холбогдлын тухайд, эрдэмтэн Е.К.Скрибник “Хэрэв үйлт нэр, нөхцөл үйлээр илэрч байгаа үйлийн эзэн субъект нь гол үйлийнхээ эзэнтэй давхцаж байвал тэрхүү үйлийн тэрхүү үйлт нэр, нөхцөл үйл нь үйлийн эзэнд хамаатуулах нөхцлөөр хэлбэржсэн байна. Хэрэв үйлт нэр, нөхцөл үйлээр илэрсэн үйлийн эзэн нь гол үйлийнхээ эзэнтэй эс тохирч байвал өөр эзэнтэй хам бүтэц байх бөгөөд тэрхүү үйлт нэр, нөхцөл үйл нь биед хамаатуулах (личное притяжение) илтгэгчтэй байж болно.”(1980,х.118) гэж



дүгнэсэн. Тэгвэл, эрдэмтэн Б.Пүрэв-Очир үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэрийг өгүүлэхүүний нь цуваа, байрлал, хэлзүйн хэлбэрийн талаас ажиглан, үйлийн нэг эзэнтэй, эрхшээлт бус олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр, үйлийн нэг эзэнтэй, эрхшээлт олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр гэж ангилаад, өгүүлэхүүний хэлзүйн хэлбэрийн тухайд “Нэгд, үйлийн эзний хамаатал нь (субъектное притяжение) нэрлэх тийн ялгалтай шүтэлцээтэй, хоёрт, биед харьяалах хамаатал нь (личное притяжение) харьяалах, заахын тийн ялгалтай шүтэлцээтэй байна.”(2010, х.273) гэж тайлбарласан бол, эрдэмтэн М.Базаррагчаа “Өгүүлэгдэхүүн хэлхэц нь өгүүлэхүүн гишүүнд, өгүүлэхүүн хэлхэц нь өгүүлэгдэхүүн гишүүнд тус тус холбогддог бол өгүүлэгдэхүүн хэллэг нь өгүүлэхүүн хэллэгийг шаардана. (СХСэтгүүл, 1986.№6.х.92.) хэмээн хэлхэц өгүүлбэрийн өгүүлэхүүнийх нь цуваа, байрлал, шинж чанар, хэлзүйн хэлбэр, харьцаа хамаарлын талаар харьцангуй өргөн хүрээтэй судалсан гэж үзэж болох юм.

Дөрөвт, Үйлийн нэг эзэнтэй, олон өгүүлэхүүнтэй өгүүлбэрийн бусад өгүүлбэр (энгийн ба нийлмэл өгүүлбэр)-тэй ижил төстэй шинжийн талаар, “Монгол хэлний дээр дурдсан хэв шинжийн өгүүлбэр нь учир зүйн хувьд хэд хэдэн хэллэг буюу өгүүлэх нэгж болон задрах шинжтэй бөгөөд үүгээрээ нийлмэл өгүүлбэрт ойр юм” (Пүрэв-Очир, 1997),

“А. Багш хэлэв. (энгийн өгүүлбэр), Б. Морь унасан хүн ирлээ. (хэлхэц), В. Батыг очиход багш баяр хүргэжээ. (хуурмаг нийлмэл өгүүлбэр буюу хэллэг), Г.Бат очно гэж багш хэлэв. (жинхэнэ нийлмэл өгүүлбэр) гэж ангилж болмоор санагдана... “а,г” өгүүлбэр нь энгийн ба нийлмэл өгүүлбэрийн тус тусын шинжийг дор дороо агуулсан, гоц ялгарах бүтэцтэй бол “б,в” өгүүлбэр нь “а,г” хоёрын завсрын шинжтэй бүтэц бүхий өгүүлбэрүүд юм.” (Базаррагчаа, 1986) хэмээн үйлийн эзний тоогоор, эсвэл үйлийнхээ тоогоор энгийн өгүүлбэр болон задарч чаддаг, энгийн ба нийлмэл өгүүлбэрийн аль алинд нь ойр өвөрмөц сонин бүтэцтэй хэв шинж

болох тухайд нотлон тайлбарласан байна. Харин, монгол хэлний үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй хам бүтэц нь дундын ижил гишүүнтэй байх, зэрэгцлийн эгнээ үүсгэх өвөрмөц онцлогтой талаар дурдсан нь ховор байна.


Судалгааны үр дүн

Хэлний аль ч түвшний нэгж, түүний хувилбарын тухай асуудал бол хэлний тогтолцоот чанартай салшгүй холбоотой байдаг. Тэгвэл, монгол хэлний үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр нь аль нэг гишүүний зэрэгцэл, аль нэг гишүүний хэлхэц дээр түшиглэдэг завсрын түвшний өвөрмөц тогтолцоот хам бүтэц юм. Иймд, өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбоо, өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүн, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрт байх үндсэн онцлогийг зарим талаараа хадгалж, дундын элементээр бүлэглэгдэх шинжтэй гэж үзэж болох юм. Үүнийг дараах хэлний баримт жишээгээр тодруулан авч үзье.

1. Үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өвөрмөц өгүүлбэрийн нэг хэсэг нь нэг нь нөгөөгөө эрхшээн захирсан хэд хэдэн өгүүлэхүүнтэй байх бөгөөд эдгээр нь дундын ижил өгүүлэгдэхүүн гишүүнтэйгээ харилцан захируулан холбоонд суурилсан онцлог шинжтэй. Тухайлбал,

Хэрмэн цоотгор баавгайн нуруунаас **үсэрч буунгуутаа** буруулан **зугтаж**, эзэндээ тулгарсан аюулыг **холдуулж чадлаа**. (Б.Н), Да багш гэж олонд алдаршсан **энэ хүн** хар бага наснаасаа насан эцэс болтлоо эрдэм ном **сурч**, **судалж сурталчилж**, **ганцхан чигийг барьж явсан**, жинхэнэ **номын хүн байж дээ** гэж аргагүй л бодогдох юм. (“Утга зохиол, урлаг” сонин, 1988, №38), **Тэр** ном **уншиж эхэлмэгцээ** бүх зовлонгоо **мартаж**, бүгдийг **мартаж...**(Л.Б), **Би** дээд сургуулиа **төгсөнгүүтээ** энэ үйлдвэрт **ирсэн** гэдгийг чи андахгүй.(Ч.Н) гэх мэт жишээ олныг дурдах боломжтой ч зөвхөн нэгийг дундын ижил гишүүний талаас загварчилж харвал, **Тэр хоёр**, заасан зүгт нь **хурдлан явах зуураа**¹ өнөөх хүүхний морь, уургалахыг² сонирхон **харжээ**³. (Ш.Г)

Загвар 1. Дундын ижил өгүүлэгдэхүүн



Дээрх жишээнд угсарсан өгүүлэхүүн гишүүд дундын ижил өгүүлэгдэхүүн гишүүн буюу дундын нэг эзэнтэй байна

1. Үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өвөрмөц өгүүлбэрийн нэг хэсэг нь зэрэгцсэн хэд хэдэн өгүүлэхүүнтэй байх бөгөөд эдгээр нь дундын ижил өгүүлэгдэхүүн гишүүнтэйгээ харилцан захируулан холбоонд суурилсан онцлог шинжтэй. Энэ хэв шинжийн өгүүлбэр харьцангуй түгээмэл гэж хэлж болно. Тухайлбал,

Хөх монголын **нүүдэл**
Хөсөг тэргээ **орхихгүй**,
Буурлын сургаалаас **холдохгүй**,
Буянт малаасаа **хөндийрөхгүй**. (Д. Н)


Шинийн нэгний өдөр **аав**, өвөг аавын аяганд айраг **хийж** сөнгийн дэргэд **тавив**. **Тэр** шүүгээ **уудлан** хар даавуунд нандигнан боосон юм **гаргаж ирэнзадлав**. **Чогсом** бяруугаа хашаанд **оруулж**, байр байдлыг нь **ажин** хэсэг **зогсож байгаад** гэртээ **оров**. (Д.Б), Үе тэнгийн **хоёр эхнэр** үдмэлийг **үүрч**, матмалыг **барьж**, хөх ногооны униар дунд эгэл амьдралынхаа илч гэрлийг **түүсээр оджээ**. (С.Д), Тэгээд ч, манайхан уулаа **бараадаж**, бэлд нь **зусна**. (Н.Ө) гэх мэт зэрэгцсэн үйл өгүүлэхүүнтэй, Номын утга нь тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн. (Ц.Д), **Эх хүн бол** хүн төрөлхтний хаан, амьдралын гоо сайхны **бүрдэл юм**. (Ч.Л),

Буддын ёсны **шинжлэх ухаан бол**
Бурангуй ёсыг эвдэгч **илд**
Бүдүүлэг байдлыг гэгээрүүлэгч **толь**

Бүх хүн төрөлхтний **нөхөр мөн**. (Д.Нацагдорж) гэх мэт зэрэгцсэн нэр өгүүлэхүүнтэй, нэг эзний олон үйлтэй хам бүтцүүд байна. Ийм хэв шинжийн өгүүлбэрээс нэгийг жишээлж, задлал хийж харвал,

Морь нь үе үе амгай **тачигнуулан**¹, өвс ногоо шир шир **хазална**.² (Д.Батбаяр)

Загвар2. Дундын ижил өгүүлэгдэхүүн ба зэрэгцлийн эгнээ




Дээрх жишээ өгүүлбэрт өгүүлэхүүн гишүүд зэрэгцлийн эгнээ үүсгэсэн бөгөөд дундын ижил өгүүлэхүүн гишүүн (дундын ижил үйлийн эзэн)-тэй байна.

1. Тухайн мэдэгдлийг илрүүлж байгаа өгүүлбэрүүд нь хэлэхүйн цуваанд тодорхой байр харьцаанд орохдоо утга, бүтэц, хэлбэрийн хувьд бие биедээ харилцан нөлөөлж, ингэснээр өгүүлбэрийн хувилбар үүсдэг. Үйлийн нэг эзэнтэй олон өгүүлэхүүнтэй өгүүлбэрийн хувьд хэлхэц гишүүлбэрээс шалтгаалж хувилбар өгүүлбэр үүсч байгаагийн нэг жишээ нь олон эзний нэг үйлтэй өвөрмөц хам бүтэц юм. Энэ нь бүтцийн ерөнхий хэв шинжээрээ дээр өгүүлсэн 1 ба 2 дахь хэв шинжтэй эсрэгцсэн хам бүтэц юм.



Тухайлбал, **Хан улс, Хүннү улс хоёр бол** мөр зэрэгцэх хүчирхэг **хөрш улсууд юм.** (Түүх 1), **Үхэр, хонь** хааяа нэг хэвж хэвтэнэ. (Д.Н), **Төрийн сүлд, туг, далбаа, дуулал бол** монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг **илэрхийлнэ.** (Үндсэн хуулиас), **Газар дэлхий, нарт тэнгэр, ээж минь** надаас салхиараа, гэрлээрээ, харцаараа **зүүгдэн эргэлдэнэ.** (Д.Б), **Баадай ч, Бурмаа ч** хэн хэндээ дээлний тухай **цухуйлгасангүй.** (Ж.Д) гэх мэт жишээний сүүлчийн нэг өгүүлбэрийг зэрэгцлийн эгнээ ба дундын ижил гишүүний талаас загварчилж харвал,

Загвар 3.Зэрэгцлийн эгнээ ба дундын ижил өгүүлэхүүн




Дээрх жишээнд өгүүлэгдэхүүн гишүүд зэрэгцлийн эгнээ үүсгэсэн бөгөөд дундын ижил өгүүлэхүүн гишүүн (дундын ижил үйл)-тэй байна.

1. “Нэг өгүүлэгдэхүүн нь хэд хэдэн өгүүлэхүүнтэй байж болно. Зэрэгцсэн өгүүлэхүүнээс бусад гишүүн зэрэгцэж орвол хэлхэц болно. (Базаррагчаа,1999.х.73) гэснийг үндэслэн хэлхэцийг үүсгэж буй зэрэгцлийн эгнээ, дундын ижил гишүүнийг дараах жишээн дээр загварчлан тайлбарлавал,


Тэрбиш гаднаа бууж, **номхон хул мориныхоо** эмээл хазаарыг аваад, хондлой дээр нь аяархан алгадахад хул морь хэд алхаад өвс зулгааж эхлэв. (Б.Б)

Загвар 4. Зэрэгцсэн тодотгол ба дундын ижил гишүүн



Энэ жишээнд нэрийн тодотгол гишүүд зэрэгцлийн эгнээ үүсгэж, дундын ижил тодотгол гишүүндээ угсарч захирагдсан бол,


Загвар 5. Зэрэгцсэн тусагдахуун ба дундын ижил гишүүн




гэсэн загвараас харахад шууд тусагдахуун гишүүд зэрэгцлийн эгнээг үүсгэж, дундын ижил тодотгол гишүүнийг угсруулах холбоогоор захирсан байна.

Орны хажуугийн явган ширээн дээр халуун савтай цай, мойлтой хурууд, цөцгий зэргийг авчирч тавьсан нь буудлынхан намайг их л анхаарсны тэмдэг. (С.Э)

Загвар 6. Зэрэгцсэн байц ба дундын ижил гишүүн



Дээрх жишээнд, шууд тусагдахуун гишүүд зэрэгцлийн эгнээ үүсгэж, дундын ижил өгүүлэхүүн гишүүнд угсруулах холбоогор захирагдсан бол,



Зэрэгцсэн байц ба дундын ижил гишүүн байц гишүүд зэрэгцлийн эгнээг үүсгэж, дундын ижил өгүүлэхүүн гишүүнд угсруулах холбоогоор захирагдсан байна. Энэ мэтчилэн хэлхэц гишүүд зэрэгцлийн эгнээг үүсгэн, дундын ижил аль нэг гишүүнд холбогдох замаар хэлхэц өгүүлбэрийн бүтэц тогтолцоот хэв шинж бүрддэг гэж үзэж болох юм.

ДҮГНЭЛТ

1. Үйлийн нэг эзэнтэй, олон өгүүлэхүүнтэй өгүүлбэр, түүнтэй эсрэгцсэн хам бүтэц олон эзний нэг үйлтэй өгүүлбэрийн хэвшинжийн өгүүлбэрийг ерөнхийд нь “хэлхэц өгүүлбэр” гэж нэрлэх нь илүү оновчтой байна.
2. Хэлхэц өгүүлбэр ба хэлхэц нь зэрэгцлийн эгнээг үүсгэнэ, дундын ижил гишүүнтэй байна.
3. Зэрэгцсэн ба угсарсан хэлхэцийн аль аль нь дундын ижил гишүүнтэй байна.
4. Хэлхэц өгүүлбэрийг өгүүлбэрзүйн харьцаа холбоо талаас зэрэгцсэн хэлхэц, угсарсан хэлхэц гэж ангилж болох мэт.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Ахманова, О.С. (1966). Словарь лингвистических терминов, Москва.
- Базаррагчаа, М. (1986 №6). Монгол хэлний нийлмэл өгүүлбэрийн тухай асуудалд. Сурган хүмүүжүүлэгч сэтгүүл. Улаанбаатар.
- Базаррагчаа, М. (1987). Монгол хэлний өгүүлбэр, Улаанбаатар.
- Базаррагчаа, М. (1999). Монголхэл VIII. Улаанбаатар. “Тоонот принт” ХХК.
- Базаррагчаа, М. (2005). Монгол хэлний өгүүлбэр судлал, Улаанбаатар.
- Барайшир, Ш. (1985 №5). “Өгүүлбэрийн хэв шинжийн тухай асуудалд”, Сурган хүмүүжүүлэгч



сэтгүүл, Улаанбаатар.

Бертагаев, Т.А. (1964). Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении (Простое предложение). Москва.

Лувсанвандан, Ш., ред. (1966). Орчин цагийн монгол хэлний зүй. Улаанбаатар. “Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо”.

Лувсанвандан, Ш. (1977). “Орчин цагийн монгол хэлний үгэлбэрийн бүтцийг судлах тухай асуудалд”. Хэл зохиол, XXI боть, Улаанбаатар.

Пүрэв-Очир, Б. (1997). Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, Улаанбаатар.

Пүрэв-Очир, Б. (2010). Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 1. Улаанбаатар.

Пюрбеев, Г. Ц. (1984 №4). “Об актуальности типологического изучения синтаксиса предложения монгольских языков” Вопросы языкознания. Москва.

Скрибник, Е. К. (1980). О синтаксическом функционировании показателей притяжения в монгольских языках, Новосибирск.